

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БУЛГАН АЙМГИЙН ТЕЗ-ИЙН 2021 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: БУА-2022/01/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Булган аймаг
2022 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ
Утас: 7034-2580 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 7034-2716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Намчинсүрэн
Утас: 7034-2495 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дээрх хаягаар авна уу.

Тайланг бэлтгэсэн:		Агуулга
Тэргүүлэх аудитор	Б.Эрдэнэ	Товчилсон үгийн жагсаалт2 Хүснэгтийн товьёг.....3 Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....5
Аудитын менежер	Ж.Энхцоодол	Үндсэн мэдээлэл 1.1 Төсвийн зорилт.....6 1.2 Төсвийн бүтэц.....6 1.3 Төсвийн онцлог.....6-7
Ахлах аудитор	Г.Намчинсүрэн	Бүлэг 1. 1.1 Орлогын гүйцэтгэл.....8-9 1.2 Зарлагын гүйцэтгэл.....9-13
		Бүлэг 2. Татварын зарлага.....13
		Бүлэг 3. Худалдан авсан бараа ажил, үйлчилгээний гүйцэтгэл.....13-14
Хаяг: Булган аймаг ЗДТГ байр. 4 давхар 410 тоот		Бүлэг 4. Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн.....15-17
		Бүлэг 5. Нэмэлт төсвийн гүйцэтгэл.....17-18
Цахим хуудас: Tailan.audit.mn		Бүлэг 6. Засгийн газрын өр болон Засгийн газрын өрийн баталгааны мэдээлэл.....18-19
		Бүлэг 7. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт.....19
		Дүгнэлт19
Аудитын тайлантай холбоотой асууж тодруулах зүйл байвал 7034-2495, 7034-2580 дугаарын утсаар харилцана уу.		Зөвлөмж20

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АТБӨЯХАТ	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УИХ	Улсын Их Хурал
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТТАМНАТ	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
ТҮА	Тохижилт үйлчилгээний анги
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ЭӨЦС	Эрдмийн өргөө цогцолбор сургууль

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт	8
Хүснэгт 2	Өмнөх онтой төсвийн орлогыг харьцуулбал	9
Хүснэгт 3	Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл	10
Хүснэгт 4	Зардлын ангилал	10
Хүснэгт 5	ЕБС, СӨБ-ийн тогтмол зардал	11
Хүснэгт 6	Худалдан авсан бараа ажил, үйлчилгээний гүйцэтгэл	13
Хүснэгт 7	ТЕЗ-ийн хэрэгжүүлсэн хөтөлбөр	15
Хүснэгт 8	ТЕЗ-ийн хэрэгжүүлсэн арга, хэмжээ	16
Хүснэгт 9	Нэмэлт санхүүжилтийн орлого	18
Хүснэгт 10	Дамжуулан зээлдэх гэрээ	18

**Аудит хийх
үндэслэл, бүрэн
эрх**

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн
талаарх мэдэгдэл**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Төсвийн тухай хуулийн 8.9.2¹-д заасан бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн бэлтгэсэн Булган аймгийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийв.

¹ “Орон нутгийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлддүгнэлт өгөх”

<p>Аудитын зорилт</p>	<p>2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалтаар аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийг мэдээллээр хангахад энэхүү аудитын чиглэгдлээ.</p>
<p>Аудитын хамарсан хүрээ</p>	<p>Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.1-54.5.5-т заасны дагуу аймгийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Аймгийн нэгдсэн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, түүний танилцуулга /<i>нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/</i> ➢ Татварын зарлагын судалгаа /<i>иргэдэд олгосон ХХОАТ-ын хөнгөлөлт/</i> ➢ 2021 оны худалдан авалтын төлөвлөгөө, гүйцэтгэл. ➢ Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл. ➢ Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, үр дүн /<i>Хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, түүний үр дүн нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан шалтгаан/</i>
<p>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</p>	<p>Аудитыг гүйцэтгэхдээ АОУС, Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан санхүүгийн гарын авлага, аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон Санхүү төрийн сангийн хэлтэс, байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, судалгаа авах, дансны хуулгатай тулган баталгаажуулах, тоон мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсруулав. Аудитын нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.</p>
<p>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</p>	<p>Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Д.Анхбаяр удирдаж, аудитын менежер Ж.Энхцоодол үе шатны ажлын чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Намчинсүрэн нар 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.</p> <p>Аудит хийхэд учирсан хүндрэл бэрхшээл:</p> <p>ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хүндрэл бэрхшээл гарсангүй.</p>

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

1.1. Төсвийн зорилт

Орон нутгийн төсвийг аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан үндсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглүүлсэн байна. Үүнд:

- ✚ Цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээний нөлөөллөөр үүссэн төсвийн алдагдлыг 2021 онд бууруулан төсвийн тогтвортой байдлыг хангаж, мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлнэ.

- ✚ Цар тахлын үед хэрэгжүүлж буй иргэдийн орлогыг хамгаалах, аж ахуйн нэгжийг дэмжих зарим арга хэмжээг хилийн хориог цуцлах хүртэлх хугацаагаар буюу ирэх оны эхний хагас жилд үргэлжлүүлнэ.
- ✚ Татвар нэмэлгүй бизнесийн орчныг үргэлжлүүлэн дэмжиж, гаалийн шинэчлэлийн үр дүнд экспортыг нэмэгдүүлж, баялгаас орох бүрэн хураах, технологийн дэвшил ашиглан татварын бүртгэл, хамрагдалтыг сайжруулж, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагааны түвшинг нэмэгдүүлж төсвийн орлогын боломжит эх үүсвэрийг дайчилна.
- ✚ Төсвийн урсгал зардлыг Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2013 оны төсвийн төсөөллийн түвшинд нийцүүлэх, эрүүл мэнд, боловсролын салбарын шинэчлэлийг эхлүүлэх, нийгмийн даатгал, нийгмийн хамгааллын үйлчилгээг цар тахлын үед иргэдийн орлогыг хамгаалж, нийгмийн эмзэг бүлэгт чиглүүлнэ.
- ✚ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж эхэлсэн ажлуудыг дуусгана.

1.2 .Төсвийн бүтэц:

Аймгийн нэгдсэн төсөв нь аймгийн шууд харьяа байгууллагууд болон сумын төсөв гэсэн 2 хэсгээс бүрддэг. 2021 оны орон нутгийн төсөв нь дараах үндсэн бүтэцтэй байна. Үүнд:

1. Аймгийн болон сумдын төсөв
2. Аймаг, сумын ОНХС-д олгох шилжүүлэг
3. Сумдад олгох санхүүгийн дэмжлэг
4. Улсын төсвийн тусгай зориулалтын шилжүүлэг

1.3 Төсвийн онцлог:

Төсвийн урсгал зардлыг Монгол улсын 2021 оны төсвийн тухай хууль, холбогдох бусад хууль, эрх зүйн хүрээнд хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой орон нутагт үүссэн тулгамдсан асуудал, зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, өр төлбөр үүсгэхгүй байх нөхцөлийг хангах, төсвийн үргүй зардлыг багасгах, хэмнэлтийн горимыг сахих, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлийг баримталжээ.

Төсвийн орлого 71,284,678.3 мянган төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 76,327,691.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 5,043,013.2 мянган төгрөг буюу 7.1 хувиар давсан, Төсвийн зарлага 75,763,766.4 мянган төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 68,629,705.52 мянган төгрөгийг зарцуулж, 7,143,615.0 мянган төгрөг буюу 9.4 хувиар дутуу зарцуулсан байна.

Өмнөх оны төсвийн гүйцэтгэлтэй харьцуулахад төсвийн орлого 8,379,320.6 мянган төгрөг буюу 12.3 хувиар, зарлага 4,101,463.42 мянган төгрөг буюу 6.4 хувиар өссөн байна.

УИХ-аас аймгийн төсвийн суурь орлогыг 23,296,000.0 мянган төгрөг, суурь зарлагыг 26,080,795.00 мянган төгрөгөөр баталсан байна.

УИХ-аас Монгол Улсын төсвөөс 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулж аймгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг 3,567,112.2 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 4,244,220.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

БҮЛЭГ 1. ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

1.1 ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ

2021 оны төсвийн орлогыг бүрдүүлэхдээ төсвийн тэнцвэрт харьцааг хадгалах хэмжээнд орлогын боломжит эх үүсвэрийг бүрэн дайчлах, төсвийн орлогын тогтвортой бааз суурийг өргөжүүлэх, татварын ногдуулалт, төлөлтөд тавих хяналтыг сайжруулах, Сангийн яамнаас ирүүлсэн чиглэл, аймгийн ЗД-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг нийгмийг

хөгжүүлэх зорилтыг хангах ажлын хүрээнд төсвөөс санхүүжигдэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд анхаарч ажиллажээ.

Орон нутгийн төсвийн нийт орлого төлөвлөгөөнөөс 7.1 хувиар давж биелсэн боловч зарим нэр төрлийн татварын орлого тасарсан.

Хүснэгт 3: Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт / мянган төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО	71,284,678.30	76,327,691.50	-5,043,013.20	107.1
Татварын орлого	23,564,668.70	29,705,046.40	-6,140,377.70	126.1
Орлогын албан татвар	5,722,683.50	6,637,362.70	-914,679.20	116.0
Хувь хүний орлогын албан татвар	6,322,683.50	7,054,004.40	-731,320.90	111.6
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(600,000.00)	-416,641.60	-183,358.40	69.4
Хөрөнгийн албан татвар	1,334,499.40	2,914,986.90	-1,580,487.50	218.4
Бусад татвар, төлбөр, хураамж	16,507,485.80	20,152,696.80	-3,645,211.00	122.1
Бусад нийтлэг төлбөр, хураамж	526,801.10	576,842.90	-50,041.80	109.5
Газрын төлбөр	891,444.10	1,215,245.90	-323,801.80	136.3
Байгалийн нөөц ашигласны төлбөр	15,029,240.60	18,245,603.40	-3,216,362.80	121.4
Бусад татвар	60,000.00	115,004.60	-55,004.60	191.7
Татварын бус орлого	47,720,009.60	46,622,645.10	1,097,364.50	97.7
Нийтлэг татварын бус орлого	4,620,981.20	5,033,661.60	-412,680.40	108.9
Хөрөнгийн орлого	25,000.00	81,199.80	-56,199.80	324.8
Тусламжийн орлого	556,044.50	317,515.60	238,528.90	57.1
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	42,517,983.90	41,190,268.10	1,327,715.80	96.9
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	34,706,651.70	33,378,936.00	1,327,715.70	96.2
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	4,244,220.00	4,244,219.90	0.10	100.0
Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	3,567,112.20	3,567,112.20	0.00	100.0
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	4,479,088.10			0.0

Эх сурвалж: Булган аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Төсвийн орлогын гүйцэтгэлийг бүтцээр нь авч үзвэл татварын орлого 39.1 хувь, татварын бус орлого 6.7 хувь, хөрөнгийн орлого 0.1 хувь, тусламж, санхүүжилтийн орлого 54.3 хувийг бүрдүүлжээ.

Өмнөх оны гүйцэтгэлээс 12.3 хувь буюу 8,379,320.6 мянган төгрөгөөр орон нутгийн орлого нэмэгдсэн байна.

Хүснэгт 4: Өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулбал: мянган төгрөг

Төсвийн орлогын ангилал зүйл	2020 оны гүйцэтгэл		2021 оны гүйцэтгэл		Зөрүү	
	Дүн	Хувийн жин	Дүн	Хувийн жин	Зөрүү	Хувь
НИЙТ ОРЛОГО	67,948,371.00	100	76,327,691.61	100	8,379,320.61	12.3
УРСГАЛ ОРЛОГО	28,199,873.00	41.5	34,819,907.91	45.6	6,620,034.91	23.5

ТАТВАРЫН ОРЛОГО	23,314,634.70	82.7	29,705,046.40	85.3	6,390,411.70	27.4
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,885,238.30	17.3	5,114,861.51	14.7	229,623.21	4.7
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	39,748,498.00	58.5	41,507,783.70	54.4	1,759,285.70	4.4

Эх сурвалж: Булган аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нээгээсэн тайлан.

Татварын орлогын төлөвлөгөө 6,140,377.7 мянган төгрөг буюу 26 хувиар давсан байна. Үүнд: 3,336.5-3,037,109.1 мянган төгрөгөөр буюу 100-155 хувь биелсэн 10 нэр төрлийн орлого, 55,004.5 – 252,650.3 мянган төгрөгөөр буюу 191-1363.3 хувь биелсэн 5 нэр төрлийн орлого, бусад татвар 2,000.0 мянган төгрөг буюу 100 хувь, шууд бус орлого 35,404.9 буюу 70.8 хувь, ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж 1,511.9 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна./Хавсралт-1/

Татварын бус орлогын төлөвлөгөө 1,097.3 мянган төгрөгөөр буюу 2.2 хувиар тасарсан ч орлогын нэр төрлөөр 30,457.9-255,632.4 мянган төгрөгөөр буюу 115.3-324.8 хувиар биелсэн 5 нэр төрлийн орлого, 5,540.0-1,327,715.3 мянган төгрөгөөр буюу 2.5- 42.9 хувиар тасарсан 4 нэр төрлийн орлого, 100 хувь биелсэн 2 нэр төрлийн орлого байна.

Татварын орлогын давж биелсэн болон, тасарсан нь дараах нөхцөл байдлаас үүссэн байна. Үүнд:

- ✚ Хувь хүний орлогын албан татварын орлого 731,320.9 мянган төгрөгөөр буюу 16 хувь даван биелсэн ч шууд бус орлого 358,404.9 мянган төгрөгөөр буюу 70.1 хувиар тасарсан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор иргэд хялбаршуулсан журмаар буюу 1 хувиар татвар төлдөг болсонтой холбоотой байна.
- ✚ Хөрөнгийн орлогын албан татвар 1,580,487.5 мянган төгрөгөөр буюу 118.4 хувиар давж биелсэн нь малд ногдуулах албан татварын орлогын төлөвлөгөөг зарим сумд ИТХ-аар батлуулаагүйтэй холбоотойгоор 786,199.3 мянган төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн албан татварыг өмнөх онд ИТХ -аас салбар компаниудын үл хөдлөх хөрөнгийн албан татварыг нэг хувь болгон өөрчилж орлого даван биелсэнтэй уялдуулан тайлант оны ҮХХАТ-ыг бодитой төлөвлөөгүйгээс 694,162.8 мянган төгрөгөөр, тус тус давж биелсэн байна.
- ✚ Газрын төлбөрийн дуудлага худалдааны орлого 252,650.3 мянган төгрөгөөр буюу 12.6 дахин давж биелсэн нь газрын дуудлага худалдааны орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөдөггүйтэй холбоотой байна.
- ✚ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого 3,216,362.8 мянган төгрөгөөр буюу 21.4 хувиар давж биелсэн нь үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн 2020 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр төлөвлөсөнтэй холбоотой байна.

1.2 ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

Орон нутгийн төсвийн нийт зарлага 75,763,766.4 мянган төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр 68,629,705.5 мянган төгрөг зарцуулж, 90.6 хувийн гүйцэтгэлтэй, энэ нь өмнөх оноос 4,101,463.4 мянган төгрөгөөр нэмэгджээ.

Төсвийн зардлын бүтцээр нь эдийн засгийн ангиллаар авч үзвэл урсгал зардалд 96.3 хувийг зарцуулсан ба үүнээс бараа үйлчилгээний зардалд 88.6 хувь, татаас урсгал шилжүүлэгт 7.79 хувь, хөрөнгийн зардалд 1.5 хувь, төсөл сангийн зээлийн зардалд 2.17 хувийг тус тус зарцуулжээ.

Хүснэгт 5: Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл: мянган төгрөг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	75,763,766.40	68,629,705.52	7,134,060.88	90.6
НИЙТ ЗАРЛАГА	73,005,011.60	67,142,767.06	5,862,244.54	92.0
УРСГАЛ ЗАРДАЛ	71,578,065.70	66,139,486.85	5,438,578.85	92.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	63,983,140.40	60,792,139.90	3,191,000.50	95.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	35,403,217.20	34,256,673.00	1,146,544.20	96.8

Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,774,381.40	4,450,010.40	324,371.00	93.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,497,551.60	8,347,967.10	149,584.50	98.2
Хангамж, бараа материалын зардал	1,326,947.50	1,294,557.50	32,390.00	97.6
Нормативт зардал	2,232,868.50	1,836,425.50	396,443.00	82.2
Эд хогшил, урсгал засварын зардал	1,353,081.80	1,282,207.30	70,874.50	94.8
Томилолт, зочны зардал	220,105.40	158,351.30	61,754.10	71.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,253,920.00	1,210,777.90	43,142.10	96.6
Бараа үйлчилгээний бусад зардал	8,921,067.00	7,955,169.90	965,897.10	89.2
ТАТААС	100,567.00	88,275.20	12,291.80	87.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,494,358.30	5,259,071.75	2,235,286.55	70.2
Засгийн газрын урсгал шилжүүлэг	5,930,076.50	3,795,967.65	2,134,108.85	64.0
Бусад урсгал шилжүүлэг	1,564,281.80	1,463,104.10	101,177.70	93.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,426,945.90	1,003,280.21	423,665.69	70.3
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	2,758,754.80	1,486,938.46	1,271,816.34	53.9

Эх сурвалж: Булган аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нээлтгэсэн тайлан.

Бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимд шилжих, зөвхөн зайлшгүй шаардлагатай зардлыг батлагдсан төсөвт багтаан санхүүжүүлэн ажилласан байна.

Зардлын гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулахад татаас болон урсгал шилжүүлгийн зардал 29.8 хувиар, бараа ажил үйлчилгээний бусад зардал 5.1 эргэж төлөгдөх зээл 20.4 хувиар нэмэгдэж, хөрөнгийн зардал 24.0 хувиар тус тус буурчээ.

Хүснэгт 6: Зардлын ангилал

мянган төгрөг

Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны гүйцэтгэл	Өөрчлөлт	Өөрчлөлтийн хувь
Нийт зарлага ба ний зээлийн дүн	64,528,242.10	68,629,705.52	4,101,463.42	6.4
Урсгал зардал	61,973,578.50	66,139,486.85	4,165,908.35	6.7
Бараа, ажил үйлчилгээний зардал	57,853,963.90	60,792,139.90	2,938,176.00	5.1
Татаас ба урсгал шилжүүлэг	4,119,614.60	5,347,346.95	1,227,732.35	29.8
Хөрөнгийн зардал	1,319,508.80	1,003,280.21	-316,228.59	-24.0
Эргэж төлөгдөх зээл	1,235,154.80	1,486,938.46	251,783.66	20.4

Эх сурвалж: Булган аймгийн ТЕЗ-ийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.

Тайлант оны төсвийн хэмнэлт дараах шалтгаануудаас үүдэлтэй байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 1,470,915.2 мянган төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан нь өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийгээгүй, төрийн захиргааны албан хаагч, СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч, төрийн үйлчилгээний албан хаагчийн орон тоо дутуу ажилласантай холбоотой байна.
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 149,584.5 мянган төгрөгөөр буюу гэрэл цахилгааны зардлаас 48,577.7, түлш халаалтын зардлаас 82,498.5 цэвэр, бохир усны зардлаас 18,506.8 мянган тус тус хэмнэгдсэн байна.
- Нормативт зардал, томилолт, зочны зардлуудад Ковид 19-тэй холбоотой сангийн яамнаас хязгаарлалт тогтоосон, сургууль, цэцэрлэгүүдийн үйл ажиллагаа зогссонтой холбоотой хэмнэлт гарсан байна.
- Тогтмол зардлын нийт хэмнэгдсэн зардлын 30.3 хувь нь ЕБС, СӨБ-ийн байгууллагуудын тогтмол зардлаас хэмнэгдсэн байна. Энэ нь тусгай шилжүүлгийн байгууллагуудын тогтмол зардлыг бодитой төлөвлөөгүйтэй холбоотой байна.

Хүснэгт: 7 ЕБС, СӨБ-ийн тогтмол зардал

/мян.төгрөг/

Байгууллагын нэр		ЕБС	СӨБ	Нийт дүн
ИТХ-аар баталсан төсөв		4,251,993.00	1,056,057.80	5,308,050.80
Төсвийн гүйцэтгэл дэх, батлагдсан төсөв		4,265,239.50	1,036,723.30	5,301,962.80
Төсвийн зөрүү		(13,246.50)	19,334.50	6,088.00
Гэрэл, цахилгаан	Батлагдсан төсөв	148,269.80	60,701.30	208,971.10
	Гүйцэтгэл	137,792.70	56,861.80	194,654.50
Түлш халаалт	Батлагдсан төсөв	3,974,563.60	4,888,384.60	8,862,948.20
	Гүйцэтгэл	3,962,776.40	4,871,000.30	8,833,776.70
Цэвэр бохир ус	Батлагдсан төсөв	102,599.10	141,585.70	244,184.80
	Гүйцэтгэл	95,266.50	127,943.10	223,209.60
Урсгал зардал	Батлагдсан төсөв	39,807.00	23,214.40	63,021.40
	Гүйцэтгэл	39,791.60	23,204.30	62,995.90

Эх сурвалж: Булган аймгийн ТЭЗ-ийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн IV дүгээр тогтоолоор баталсан ЕБС, СӨБ-ийн тогтмол зардал төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвөөс 6,088.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Аймгийн Засаг даргын А/564 дугаар захирамжаар төсөвт зохицуулалт хийж дээрх тогтмол зардлын хэмнэлтийг сумдын соёлын байгууллагын зардалд хуваарилсан байна.

- ✚ Хөрөнгийн зардал 423,665.6 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь хөрөнгө оруулалт covid-19 цар тахалтай холбоотойгоор хэрэгжээгүй худалдан авах ажиллагаа болон гэрээний хэмнэлтээс үүссэн байна.
- ✚ Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн эргэн төлөлтийг 2,758,754.8 мянган төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,486,938.4 мянган төгрөгийн зээл төлөгдөж гүйцэтгэл 53.9 хувтай байгаа нь цаашид найдваргүй авлага үүсэх эрсдэлтэй байгаад анхаарч ажиллах шаардлагатай байна. Аймгийн Засаг дарга 2021 онд аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан аймгийн нийт төсөвт нийт 2 удаагийн захирамжаар төсөвт зохицуулалт хийсэн байна. Үүнд:
- ✚ Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйл, covid -19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7¹ дүгээр зүйлийн 7¹.1 хэсгийг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “Булган аймгийн төсөв батлах” тогтоолоор батлагдсан ТЗШ-ийн байгууллагуудын байр ашиглалтын зардлаас 276,500.0 мянган төгрөгийг хасаж, сумдад олгох санхүүгийн дэмжлэгт 195,000.0, аймгийн шууд харьяа байгууллагын төсөвт 81,500.0 мянган төгрөгийн зохицуулалт хийсэн.
- ✚ Төсвийн тухай хуулийн 42 дүгээр зүйлийн 42.2, covid -19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7¹ дүгээр зүйлийн 7¹.1 хэсэг, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалын 3 дугаар зүйлийн 3.1.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны IV/05 дугаар тогтоол, БСШУ сайдын 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 1а/5843 тоот албан бичгийг үндэслэн ТЗШ-ийн байгууллагуудын байр ашиглалтын зардлаас сумдын Соёлын төвүүдийн төсөвт 6,088.0 мянган төгрөгийн зохицуулалтыг тус тус хийсэн байна.

Улсын их хурлаас Монгол Улсын тухайн жилийн төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан Засгийн газарт даалгасан хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа тогтоолууд, төсвийн хэмнэлтийн талаар Засгийн газраас гаргасан тогтоолыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлүүд давтагдсаар байна. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт:

- ✚ Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 1.1² дэх заалтыг зөрчин Засаг даргын нөөц хөрөнгийг Орхон сумын ЗДТГ 1,056.0, Хишиг-Өндөр сумын ЗДТГ 3,385.7, Дашинчилэн ЗДТГ 647.0, Сайхан сумын ЗДТГ 1,385.1, Баян-Агт сумын ЗДТГ, Баяннуур сумын ЗДТГ 1,100.0, Гурванбулаг сумын ЗДТГ 1,300.0, нийт 8,873.8 мянган төгрөг
- ✚ Цалингийн зардлаас зориулалт бусаар зарцуулалт Бүрэгхангай сумын СӨБ 681.5, Бугат сумын ЕБС 2,483.0 мянган төгрөг
- ✚ Аймгийн хэмжээнд дамжуулан зээлдэх гэрээний өглөг 12,801,535.8 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаагаас хугацаа хэтэрсэн төлбөр 2,069,995.0, хугацаа хэтэрсэн хүүгийн төлбөр 1,209,247.9, хугацаа хэтэрсэн үндсэн төлбөрт тооцоологдсон хүүгийн алданги 14,392,544.8 мянган төгрөг
- ✚ Анхан шатны баримтгүй Аймгийн ОНӨГ 650.0, Сэлэнгэ сумын ЕБС 755.3, Хот тохижилт, үйлчилгээний анги 1,813.4 мянган төгрөг, Баяннуур сумын ЗДТГ 617.9, Хишиг-Өндөр сумын ОНХС 956.0, Дашинчилэн сумын ЭМТ 515.6 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.
- ✚ Хүнсний материалаас Хутаг-Өндөр сумын ЕБС 14,302.8 мянган төгрөг, Бугат сумын цэцэрлэг 758.1, Бүрэгхангай сумын ЕБС 6,311.7 мянган төгрөг дутагдуулсан.
- ✚ Төсвийн захирагч нар Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.1, 1.4, заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй нийт 761,958.8 мянган төгрөгийг зарцуулсан. /Хавсралт/
- ✚ Төсөвт төвлөрүүлэх түрээсийн орлогыг Гурванбулаг сумын ЗДТГ 2,610.5, Дашинчилэн сумын ЗДТГ 510.0 мянган төгрөгөөр тус тус дутуу төвлөрүүлсэн.
- ✚ “Булган мээж” ОНӨ ХХК ТУЗ-ийн зөвшөөрөлгүйгээр 4.5 сая төгрөгийн гэр худалдан авсан, ТУЗ-ийн гишүүдэд хоол, шатахуун, томилот, сургалтын зардал, ТУЗ 2021 оны 01 дүгээр тогтоолоор “Булган мээж” ХХК-ийн 2017-2020 оны санхүүгийн тайланг шалгуулахаар 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор Аудитын байгууллага сонгох эрх олгосон шийдвэр гаргасан, мөн ТУЗ-ийн эрх олгосон тогтоолд аудит хийх байгууллагыг сонгон шалгаруулж, ТУЗ-д танилцуулахыг Гүйцэтгэх захиралд үүрэг болгосон байхад шууд гэрээ байгуулан “Партер мидланд аудит” ХХК-аар дүгнэлт гаргуулсан, Гүйцэтгэх захирлын нэр дээр бүртгэлтэй утасны дугаарын ярианы төлбөрийг шуудан холбооны зардлаас төлсөн, түншлэлийн зардал, шагнал урамшуулал, 90 жилийн ойн арга хэмжээний зардалд тус тус гүйцэтгэх захирлын тушаалаар 494,867.6 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулсан.

Санхүүгийн тайлангийн аудитаар зарим төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулиар хориглосон дараах үйл ажиллагааг явуулсан байна. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

- ✚ Цоожид” өрхийн эрүүл мэндийн төв 31,500.0 мянган төгрөгийн автомашиныг төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийж ТБОНӨХБАҮХАТ-ийн 8.2³ дэх заалтыг зөрчсөн.
- ✚ Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах аж ахуйн зардалд зориулж шууд болон шууд бусаар төсвийн хөрөнгийг зарцуулж Төсвийн тухай хуулийн 44.2⁴, 44.3⁵

² Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад хуулиар олгогдсон бүрэн эрхтэй зөрчилдөхгүй, урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсны улмаас тухайн төсвийн жилийн дундуур зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ, зардлыг Засаг даргын нөөц хөрөнгө (цаашид “нөөц хөрөнгө” гэх)-өөс санхүүжүүлэх, гүйцэтгэлийг тайлагнахад энэ журмыг мөрдөнө.

³ Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ.

⁴ Туслах үйл ажиллагааны зардалд тухайн үйл ажиллагааг эрхлэхтэй холбогдсон шууд болон шууд бус бүх төрлийн зардал, өглөг, санхүүгийн үүргийг оруулж тооцно.

⁵ Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно.

заалтыг зөрчсөн. Тухайлбал: Дашинчилэн сумын ЗДТГ малчны цалингийн зардалд 1,327.7, Баян-Агт сумын ЗДТГ малчны цалингийн зардалд 1,542.5, шатахууны зардалд 400.0 нийт 3,270.2 мянган төгрөг

✚ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг Төсвийн тухай хуулийн 60.3-д заасан заалтыг зөрчин зарцуулсан. Тухайлбал: Сэлэнгэ сумын ЗДТГ 1 төсөл арга хэмжээний 3,000.0, Сайхан сумын ЗДТГ 2 төсөл арга хэмжээний 12,500.0, Могод сумын ЗДТГ 5 төсөл арга хэмжээний 110,938.4, Рашаант сумын ЗДТГ 4 төсөл, арга хэмжээний 19,000.0, Хангал сумын ЗДТГ 2 төсөл, арга хэмжээний 7,080.7 нийт 14 төсөл арга хэмжээний 152,519.1 мянган төгрөг

Дээрх аудитаар илэрсэн зөрчлүүдээс дүгнэхэд Төсвийн захирагч нарын дотоод хяналт сул МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт зохион байгуулах нийтлэг” журмыг байгууллагын үйл ажиллагаанд тохируулан боловсруулж батлуулаагүй, тухайн журмыг боловсруулсан ч томилсон дотоод хяналтын баг үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулдаггүй, төлөвлөсөн ажлыг бүрэн хэрэгжүүлдэггүйтэй холбоотой байна.

Иймд цаашид төсвийн захирагчийн дотоод хяналтыг сайжруулах ажлыг зохион байгуулах, илэрсэн алдаа, зөрчлийг дахин давтах байх, дээд шатны байгууллагаас хэрэгжүүлж байгаа бодлого чиглэлийг үйл ажиллагаандаа бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

БҮЛЭГ 2. ТАТВАРЫН ЗАРЛАГА

Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 49 дүгээр зүйл, 2006 онд баталсан баталсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12, шинэчилсэн найруулсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйл, Сангийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 19 дүгээр тушаалаар батлагдсан “Илүү төлсөн албан татварыг буцаан олгох, хяналт тавих, нягтлан бодох бүртгэлд тусгах журам”-ын 2.7 дахь хэсэгт заасны дагуу нийт 813 татвар төлөгчдөд 416,641.6 мянган төгрөгийн татварын буцаан олголтыг олгосон байна.

БҮЛЭГ 3. ХУДАЛДАН АВСАН БАРАА АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн болох худалдан авсан бараа ажил, үйлчилгээний гүйцэтгэлийг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.3-д заасны дагуу тайлагнасан байна. Үүнд:

Хүснэгт 8: худалдан авсан бараа ажил, үйлчилгээний гүйцэтгэл

/мянган.төгрөг/

Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний эх үүсвэр	Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тоо	Батлагдсан төсөв	Санхүүжилт	Санхүүжилтийн хувь
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	6	510,000.00	506,246.40	99.9
Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	16	2,372,142.00	2,112,268.70	89.0
Байгаль хамгаалах сан	34	4,271,899.00	4,131,149.70	97.0
Улсын төсвийн хөрөнгө оруулалт	11	4,592,000.00	4,354,168.40	95.0
Аймгийн авто замын сан	7	325,500.00	175,157.30	54.0
Нийт дүн	74	12,071,541.00	11,278,990.50	86.9
<i>Эх сурвалж: Булган аймгийн ТЕЗ-ийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.</i>				

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт гүйцэтгэл:

Нийт 6 төсөл арга хэмжээнд нийт 510,000.0 мянган төгрөгийн хөрөнгө батлагдсанаас гүйцэтгэлээр 99 хувь буюу 506,246.4 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Үүнээс

0.1 хувь буюу 1,439.6 мянган төгрөг нь худалдан авах ажиллагааны үр дүнгээс хэмнэгдсэн байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт, гүйцэтгэл:

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймагт 4,244,219.9 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөснөөс санхүүжилтийг бүрэн олгосон байна.

ОНХНС-гаас хуваарилагдаж ирсэн санхүүжилтийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасны дагуу 2,906,466.7 мянган төгрөгийг аймагт, 1,337,753.2 мянган төгрөгийг суманд тус тус хуваарилжээ.

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр нийт 16 төсөл арга хэмжээнд 2,372,142.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 2,112,268.7 мянган төгрөгийн санхүүжилт олгосон нь 89 хувьтай байна. Үүнээс 11 хувь буюу 259,873.3 мянган төгрөг нь төсөвт үлдсэн дүн, худалдан авах ажиллагааны үр дүнгээс үүссэн хэмнэлт байна.

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээнээс 238,363.7 мянган төгрөгийн батлагдсан төсөвтэй Цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын дуусгалын санхүүжилт 43 хувь буюу 101,472.8, /Тэшиг сум/, 29,963.8 мянган төгрөгийн батлагдсан төсөвт өртөгтэй соёлын төвийн барилгын засварын ажлын санхүүжилт 9 хувь буюу 2,733.6, /Могод сум/, 41,158.5 мянган төгрөгийн батлагдсан төсөвтэй сургуулийн барилгын "б" блокийн засвар 11 хувь буюу 2,397.3 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна.

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт, гүйцэтгэл:

Сумдад ОНХНС-аас нийт 1,337,753.2 мянган төгрөгийг хуваарилснаас санхүүжилтийг бүрэн авч эх үүсвэрийг өмнөх оны зарцуулагдаагүй үлдэгдэл, бусад эх үүсвэрээр нэмэгдүүлэн нийт 155 хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээнд 3,636,176.2 мянган төгрөгийг зарцуулахаар баталснаас гүйцэтгэлээр 1,684,909.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон нь 46.3 хувьтай байна.

Нийт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээнээс 629,589.9 мянган төгрөгийн 38 хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна. Тухайлбал: Бүрэгхангай сум 5 төсөл арга хэмжээний 200,699.8, Могод сум 4 төсөл арга хэмжээний 93,938.4, Хишиг-Өндөр сум 3 төсөл, арга хэмжээний 12,226.8 мянган төгрөгийн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төсөл, арга хэмжээний санхүүжилт, гүйцэтгэл:

Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх 34 төсөл арга хэмжээнд нийт 4,271,899.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 97 хувь буюу 4,131,149.7 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Үүнээс 1.2 хувь буюу 53,626.6 мянган төгрөг нь төсөвт үлдсэн дүн болон худалдан авах ажиллагааны үр дүнгээс бий болсон хэмнэлт байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, гүйцэтгэл:

Аймгийн хэмжээнд нийт 11 төсөл арга хэмжээнд нийт 6,553,723.8 мянган төгрөгийн гэрээ байгуулагдаж, 2020 онд 4,592,000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг санхүүжүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр нийт 95 хувь буюу 4,354,168.4 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, 5 хувь буюу 237,831.6 мянган төгрөг нь төсөвт үлдсэн дүн болон гэрээний хэмнэлт гарсан байна.

Авто замын сангийн санхүүжилт, гүйцэтгэл:

Аймгийн хэмжээнд нийт 7 төсөл, арга хэмжээнд 325,500.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр батлагдаж, гүйцэтгэлээр 5 төсөл арга хэмжээнд нийт 54 хувь буюу 175,157.3 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, 46 хувь буюу 150,342.7 мянган төгрөг нь төсөвт үлдсэн дүн болон гэрээний хэмнэлт гарсан байна.

БҮЛЭГ 4. ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ, ХҮРСЭН ҮР ДҮН

Аймгийн ИТХ-аас ТЕЗ-ийн 2021 онд хэрэгжүүлэх 27 хөтөлбөр, 43 арга хэмжээнд нийт 75,763,766.4 мянган төгрөгийг зарцуулахаар батлагдаж, гүйцэтгэлээр 68,629,706.7 мянган төгрөг буюу 90.6 хувийг зарцуулж, батлагдсан 27 хөтөлбөрөөс 3 хөтөлбөр 100 хувь, 25 хөтөлбөр 50-98 хувийн гүйцэтгэлтэй буюу 7,134,059.6 мянган төгрөгийн дутуу зарцуулалт гарсан байна. Тухайлбал: Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардал 150,342.7 мянга, авто тээврийн хяналт, зохицуулалт, үйлчилгээ, нийтийн тээвэр 6000,0 мянга, гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх 16,828.63 мянга, орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 2,620,574.39 мянга, орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт 2,134,108.85 мянган төгрөгөөр дутуу зарцуулжээ.

Хүснэгт 9: ТЕЗ-ийн хэрэгжүүлсэн хөтөлбөр

/ мян.төг/

Д/д	Хэрэгжүүлсэн хөтөлбөр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хувь
1	Авто зам	325,500.00	175,157.29	53.8
2	Авто тээврийн хяналт, зохицуулалт, үйлчилгээ, нийтийн тээвэр	12,000.00	6,000.00	50.0
3	Ариун цэврийн байгууламж	88,567.00	82,275.23	92.9
4	Ахмад настны хөгжил хамгаалал	44,131.60	43,800.00	99.2
5	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	613,402.30	589,537.23	96.1
6	Батлан хамгаалахын судалгаа шинжилгээ	100,000.00	99,603.08	99.6
7	Биеийн тамир спорт	435,182.70	424,876.81	97.6
8	Газрын зураглал, кадастр	522,903.10	505,987.87	96.8
9	Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх	120,000.00	103,171.37	86.0
10	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	100,000.00	99,960.30	100.0
11	Ерөнхий боловсрол	23,259,307.00	22,631,081.62	97.3
12	Мал аж ахуйг хөгжүүлэх	607,199.70	607,199.70	100.0
13	Насан туршийн боловсрол	88,261.50	88,020.84	99.7
14	Нийгмийн халамж	76,280.00	75,030.00	98.4
15	Нийгмийн эрүүл мэнд	338,685.30	338,685.30	100.0
16	Ойжуулалт	245,843.10	231,485.43	94.2
17	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	2,000,409.60	1,882,553.61	94.1
18	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	15,874,823.40	13,254,249.01	83.5
19	Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	5,930,076.50	3,795,967.65	64.0
20	Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	146,493.20	146,330.08	99.9
21	Соёл урлаг	2,988,459.40	2,871,336.86	96.1
22	Сургуулийн өмнөх боловсрол	8,745,082.70	8,065,234.55	92.2
23	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	137,799.60	129,183.72	93.7
24	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого удирдлага	172,442.00	155,823.95	90.4
25	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	4,280,409.00	4,137,408.34	96.7
26	Хүүхдийн хөгжил, хамгаалал	289,611.70	286,500.28	98.9
27	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	8,220,896.00	7,803,246.61	94.9
	Нийт дүн	75,763,766.40	68,629,706.71	90.6

Эх сурвалж: Булган аймгийн ТЕЗ-ийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.

Хүснэгт 10: ТЕЗ-ийн хэрэгжүүлсэн арга хэмжээ

/мян.төг/

Д/д	Хэрэгжүүлсэн арга, хэмжээ	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хувь
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	19,477,502.60	18,523,182.27	95.1
2	ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	6,615,633.80	6,519,329.77	98.5
3	Нэг иргэнд ногдох нормативаар тооцсон	1,610,822.40	1,543,347.08	95.8
4	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	954,959.50	907,497.27	95.0
5	Баг, хорооны үйл ажиллагааны зардал	1,057,729.50	1,025,072.49	96.9
6	Орон нутгийн нөөц хөрөнгө	1,353,780.40	1,193,064.46	88.1
7	Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ	173,957.50	170,460.28	98.0
8	Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал	1,000.00	500.00	50.0
9	Мэдээлэл, сурталчилгааны зардал	79,920.00	75,920.00	95.0
10	Багийн ИНХ-ын даргын урамшуулал	194,410.50	184,049.35	94.7
11	Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	5,930,076.50	3,795,967.65	64.0
12	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	5,235,602.30	4,647,010.58	88.8
13	Дотоод эх үүсвэрээс олгох зээл	2,758,754.80	1,486,938.46	53.9
14	Үдийн цай хөтөлбөр	522,209.80	469,804.52	90.0
15	Дотуур байрны үйлчилгээ	2,535,857.30	2,310,819.36	91.1
16	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	15,016,751.00	14,674,479.33	97.7
17	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	8,120,058.50	7,671,145.69	94.5
18	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	481,339.00	307,172.70	63.8
19	Уран бүтээл хийлгэх	47,717.20	45,949.74	96.3
20	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	217,621.00	213,161.15	98.0
21	Бусад	1,101,445.90	808,122.90	73.4
22	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг	97,854.90	97,854.90	100.0
23	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээ, үйлчилгээ	227,534.80	227,534.80	100.0
24	Хотын доторх ногоон байгууламжийн үйлчилгээ	246,626.10	246,625.50	100.0
25	Хотын доторх золбин муур, нохой устгал	18,460.80	18,460.79	100.0
26	24 цагийн цэцэрлэг	75,878.00	58,153.12	76.6
27	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	30,680.00	30,630.00	99.8
28	Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	45,600.00	44,400.00	97.4
29	Авто зам, гүүрний байгууламж	325,500.00	175,157.29	53.8
30	Ангилалдаагүй бусад зориулалт, арга хэмжээ	150,000.00	129,334.10	86.2
31	Мал эмнэлгийн үйлчилгээ	607,199.70	607,199.70	100.0
32	Нийтийн тээврийн алдагдалд олгох татаас	12,000.00	6,000.00	50.0
33	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	88,567.00	82,275.23	92.9
34	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	44,131.60	43,800.00	99.2
35	Байгалийн гамшиг, ослын үр дагаврыг арилгах	120,000.00	103,171.37	86.0
36	Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх хөтөлбөр	100,000.00	99,603.08	99.6
38	Барилгын техник хяналт	25,848.80	25,778.72	99.7
39	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	2,645.80	2,645.80	100.0
40	Хүүхэд хамгаалал	58,089.40	58,087.26	100.0

Нийт дүн	75,763,766.40	68,629,706.71	90.6
----------	---------------	---------------	------

Эх сурвалж: Булган аймгийн ТЕЗ-ийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.

ТЕЗ-ийн хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээнд тавих дотоод хяналт нь Төсвийн тухай хуулийн 69.1⁶, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5.2.4⁷, 8.5⁸-д заасан заалтуудаар тус тус зохицуулагдсан байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь ИТХ-ийн 2020 оны II хуралдааны 9 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан ТЕЗ-ийн 2021 оны батлагдсан төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоог үзүүлэлтийн биелэлтэд дотоод аудит хийсэн байна.

Дотоод аудитаар ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх зөвхөн чанарын болон тоог үзүүлэлтийн биелэлтэд дүгнэлт гаргасан бөгөөд хөтөлбөрийн бодлогын зорилгын хэрэгжилт, хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв, хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан шалтгаанд дүгнэлт гаргаагүй байна.

Энэ нь ТЕЗ хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний хүрсэн үр дүн, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга, хэмжээний биелэлтийг дэлгэрэнгүй байдлаар төсөвтэй уялдуулан дүгнээгүйтэй холбоотой байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагч нар тухайн жилийн төсвийг батлахдаа Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.6⁹-д эдийн засгийн ангиллаар, хөтөлбөрөөр, арга хэмжээгээр, санхүүжүүлэх эх үүсвэрээр, хүрэх үр дүнгийн хамт батлах заалтыг хэрэгжүүлэн ИТХ-аар батлуулж байгаа боловч хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр, дүн түүний танилцуулгыг тайлагнаагүй байна.

Цаашид ТЕЗ өөрийн эрхлэх асуудлын хүрээний хөтөлбөрийн үр дүн, хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж, тайлагнах эрхээ бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

БҮЛЭГ 5. НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу нэмэлт төсөв түүнтэй холбогдсон үйл ажиллагааг төсвийн нэгэн адил төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах төсөвт байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансанд 7,240,867.5 сая төгрөгийн орлого дараах эх үүсвэрүүдээс орсон байна.

Хүснэгт 10: Нэмэлт санхүүжилтийн орлогын судалгаа

/мянган төгрөг/

№	Эх үүсвэрийн төрөл	Мөнгөн дүн
1	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжийн орлого	160,345.00
2	Орон нутгийн төсвийн эх үүсвэр	1,939,223.40
3	Улсын төсвийн эх үүсвэр	3,962,773.90
4	Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,178,528.20
	Нийт дүн	7,240,8767.5

Эх сурвалж: Ерөнхийлөн захирагчийн 2021 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.

⁶ Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна”

⁷ төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд хяналт тавих”

⁸Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчийн болон бусад төсвийн захирагчдын дотоод аудитын үйл ажиллагаанд дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу чанарын хяналтын үнэлгээг 2 жилд 1 удаа хийнэ”

⁹ Төсвийн төвлөрүүлэн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах;

Төсвийн тухай хуулийн 42.4 дэх “Энэ хуулийн 42.2-т заасан төсвийн зохицуулалтыг хийхэд дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг авна”, Сангийн Сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай” журмын дагуу 7,032,210.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулагдаагүй үлдэгдэл 85,728.6 мянган төгрөгийг аймгийн төсөвт, 42,138.8 мянган төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлж, Сангийн яам, Эрүүл мэндийн яамны шийдвэрээр сумдын ЭМТ-үүдийн зарцуулагдаагүй үлдэгдэл 80,790.0 мянган төгрөгийг дансны үлдэгдлээр тайлагнасан байна.

Нийт зарцуулалтын 96.1 хувь буюу 6,752,547.1 мянган төгрөгийг урсгал зардалд, 3.9 хувь буюу 279,662.9 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд тус тус зарцуулсан байна.

БҮЛЭГ 6. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР БОЛОН ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАТАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр нийт 3 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэн улсын төсөвт эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу нийт 12,801,535.8 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаагаас хугацаа хэтэрсэн төлбөр 2,069,995.0, хугацаа хэтэрсэн хүүгийн төлбөр 1,209,247.9, хугацаа хэтэрсэн үндсэн төлбөрт тооцоологдсон хүүгийн алданги 14,392,544.8 мянган төгрөг байна.

Хүснэгт 11: Дамжуулан зээлдэх гэрээ							мянган.төг
Зээлийн дугаар	Зээл гэрээ байгуулсан огноо	Эхний үлдэгдэл	Ашиглалт	Эцсийн үлдэгдэл	Хугацаа хэтэрсэн үндсэн төлбөр	Хугацаа хэтэрсэн хүүгийн төлбөр	Тооцоологдсон алданги
OL-1907MON-07	2003.12.19	1,727,686.62	0	1,727,686.62	1,120,661.59	815,000.69	14,367,816.44
OL-2301MON-05	2011.9.26	2,531,556.58	0	2,531,556.58	949,333.50	253,229.04	24,728.38
OL-3713Mon-1N	2019.08.29	6,975,006.86	1,570,363.45	8,542,292.63	0	141,018.25	0
Нийт дүн		11,234,250.06	1,570,363.45	12,801,535.83	2,069,995.09	1,209,247.98	14,392,544.82

Дамжуулан зээлдэх гэрээнд заагдсан зээлийн эргэн төлөлтийг хугацаанд нь төлж барагдуулаагүйгээс OL-1907MON-07 дугаартай зээлд тооцоологдсон алданги нь хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 1,120,661.6 мянган төгрөгөөс 12 дахин их, OL-2301MON-05 дугаартай зээлд тооцоологдсон алданги нь хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 2,531,556.5 мянган төгрөгөөс 2.6 дахин их, дамжуулан зээлдэх гэрээг эцсийн зээлдэгчтэй¹⁰ /Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн хуулийн этгээд/ гэрээ байгуулаагүй байна.

OL-3713Mon-1N дугаартай гэрээний 1.1.10-д заасны дагуу төсөл хэрэгжиж дуусах үед ашигласан зээлийн хэмжээгээр эргэн төлөлтийн хуваарийг зээлдүүлэгчтэй тооцоо нийлж шинэчилж батлаагүй байна.

Дээрх хугацаандаа эргүүлэн төлөгдөөгүй зээл, хугацаа хэтэрсэн зээлд тооцогдсон алданги нь аймгийн төсөвт ачаалал үүсгэх эрсдэлтэй байна.

¹⁰ Арийн удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-д Эцсийн зээлдэгч гэдэгт энэ хуульд заасны дагуу дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний үндсэн дээр зээлийн хөрөнгийг, хүүгийн хамт эргэн төлөх нөхцөлтэйгээр авч байгаа Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдийг ойлгоно.

Иймд төсвийн ерөнхийлөн захирагч нь Өрийн удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.2¹¹-д заасан заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж дамжуулан зээлдэх гэрээг эцсийн зээлдэгч буюу төсөл хэрэгжүүлэгч хуулийн этгээдтэй гэрээ байгуулан, зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний үр нөлөө, үр дүн хэрэгжилтэд хяналт тавих, үр өгөөжийг нь сайжруулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Мөн Өрийн удирдлагын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3-т заасны дагуу өрийн удирдлагын хэрэгжилтэд Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба аудит хийгээгүй байна.

БҮЛЭГ 7: ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

ТЕЗ-ийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд 4 зөвлөмж өгснөөс 75 хувь нь хэрэгжиж, 25 хувь нь бүрэн хэрэгжээгүй. Үүнд:

- Сумдын төсвийн төвлөрүүлэн захирагч нараас төсөвтэй холбоотой хууль, тогтоомж, журам, зааврыг мөрдөх, төсвийн сахилга, хариуцлагыг нэмэгдүүлж, төсвийн хөрөнгийг үрэлгэн, зориулалт бусаар зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоох гэсэн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Өмнөх оны төсвийн гүйцэтгэлтэй харьцуулахад төсвийн орлого 8,379,320.6 мянган төгрөг буюу 12.3 хувиар өссөн байна.
- Газрын дуудлага худалдааны орлого 252,650.3 мянган төгрөгөөр буюу 12.6 дахин давж биелсэн нь газрын дуудлага худалдааны орлогын төлөвлөгөөг бодитой байна.
- Татварын буцаан олголтоор 813 татвар төлөгчид 416,641.6 мянган төгрөгийн татварын буцаан олгосон байна.
- Төсвийн захирагч нарын дотоод хяналт сулаас дээд шатны байгууллагаас хэрэгжүүлж буй бодлого чиглэл, шийдвэр журмыг бүрэн хэрэгжүүлдэггүй, дотоод хяналт, шалгалтын зохион байгуулах журам боловсруулаагүй, дотоод хяналтын баг үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулдаггүй, төлөвлөсөн ажлыг бүрэн хэрэгжүүлж тайлагнадаггүй.
- Орон нутгийн худалдан авах ажиллагааны биелэлт 86.9 хувьтай байна.
- Төсвийн төвлөрүүлэн захирагчид хэрэгжүүлсэн хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр, дүн түүний танилцуулгыг тайлагнаагүй байна.
- Дамжуулан зээлдэх гэрээнд заагдсан зээлийн эргэн төлөлтийг хугацаанд нь төлж барагдуулаагүйгээс хугацаандаа эргүүлэн төлөгдөөгүй зээл, хугацаа хэтэрсэн зээлд тооцогдсон алданги нь аймгийн төсөвт ачаалал үүсгэх эрсдэлтэй байна.
- Өрийн удирдлагын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3-т заасны дагуу өрийн удирдлагын хэрэгжилтэд Санхүүгийн аудит, дотоод аудитын алба аудит хийгээгүй байна.
- ТЕЗ-ийн захирагчийн хэрэгжүүлэх, хөтөлбөр, хүрэх үр дүнгийн тоон болон чанарын үзүүлэлтэд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн ч хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан шалтгааныг тодорхойлоогүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИД:

¹¹ тухайн орон нутагт зээллэгийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, үйл ажиллагаанд хяналт тавих;

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	71,284,678.30	76,327,692.05	-5,043,013.75
Татварын орлого	23,564,668.70	29,705,046.67	-6,140,377.97
Орлогын албан татвар	5,722,683.50	6,637,362.75	-914,679.25
Хувь хүний орлогын албан татвар	6,322,683.50	7,054,004.39	-731,320.89
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	5,000,000.00	5,537,201.64	-537,201.64
Үйл ажиллагааны орлого	219,863.00	507,387.15	-287,524.15
Хөрөнгийн орлого	592,063.60	857,063.70	-265,000.10
Шууд бус орлого	510,756.90	152,351.90	358,405.00
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(600,000.00)	(416,641.64)	-183,358.36
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(600,000.00)	(416,641.64)	-183,358.36
Хөрөнгийн албан татвар	1,334,499.40	2,914,986.94	-1,580,487.54
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	500,000.00	1,194,162.89	-694,162.89
Бууны албан татвар	60,332.00	65,615.64	-5,283.64
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	350,000.00	444,841.63	-94,841.63
Малд ногдуулах албан татвар	424,167.40	1,210,366.78	-786,199.38
Бусад татвар, төлбөр, хураамж	16,507,485.80	20,152,696.98	-3,645,211.18
Бусад нийтлэг төлбөр, хураамж	526,801.10	576,842.97	-50,041.87
Улсын тэмдэгтийн хураамж	170,770.30	200,020.39	-29,250.09
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	98,250.00	122,582.70	-24,332.70
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	167,818.10	167,789.13	28.97
Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж	87,962.70	86,450.75	1,511.95
Бусад татвар	2,000.00	-	2,000.00
Газрын төлбөр	891,444.10	1,215,245.99	-323,801.89
Газрын төлбөр	871,444.10	942,595.68	-71,151.58
Дуудлага худалдаа	20,000.00	272,650.31	-252,650.31
Байгалийн нөөц ашигласны төлбөр	15,029,240.60	18,245,603.45	-3,216,362.85
Ойн нөөц ашигласны төлбөр	522,066.60	695,020.63	-172,954.03
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	6,074.00	9,410.50	-3,336.50
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	14,501,100.00	17,538,209.11	-3,037,109.11
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	-	2,963.20	-2,963.20
Бусад татвар	60,000.00	115,004.58	-55,004.58
Бусад татвар	60,000.00	115,004.58	-55,004.58
Татварын бус орлого	47,720,009.60	46,622,645.38	1,097,364.22
Нийтлэг татварын бус орлого	4,620,981.20	5,033,661.62	-412,680.42
Хүүгийн орлого	771,709.80	979,848.55	-208,138.75

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Торгуулийн орлого	-	255,632.40	-255,632.40
Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	3,571,871.40	3,480,870.10	91,001.30
Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	60,000.00	74,992.61	-14,992.61
Түрээсийн орлого	18,000.00	12,460.00	5,540.00
Бусад орлого	199,400.00	229,857.96	-30,457.96
Хөрөнгийн орлого	25,000.00	81,199.89	-56,199.89
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	25,000.00	81,199.89	-56,199.89
Тусламжийн орлого	556,044.50	317,515.61	238,528.89
Хандив тусламж /дотоод/	556,044.50	317,515.61	238,528.89
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	42,517,983.90	41,190,268.26	1,327,715.64
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	34,706,651.70	33,378,936.07	1,327,715.63
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	4,244,220.00	4,244,220.00	0.00
Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	3,567,112.20	3,567,112.20	0.00